

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Цөм сүргийн үржлийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/003/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Говьсүмбэр аймаг 2025 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Анхтуяа Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЦӨМ СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ А.ОТГОНТУЯА  
ТАНАА

2025.03.14 № 51

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Цөм сүргийн үржлийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн Засаг даргын 2024 оны Б/58 дугаар захирамжаар байгууллагын удирдлага солигдож ажил хүлээлцсэн ба эд хөрөнгө, төсөв санхүүтэй холбоотой зөрчлүүд илэрсэн, дотоод аудитын хяналт шалгалтаар их эрсдэлтэй гэж дүгнэсэн, тооллогоор дансанд бүртгэлтэй мал, арьс их хэмжээгээр дутсан, анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан зэрэг зөрчлүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн ба шийдвэр гараагүй тул хангалттай ба зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Энэ нь АДБОУС-200-гийн 64-д зааснаар “аудитор буруу илэрхийлэл дангаараа эсхүл нийлээд материаллаг боловч өргөн тархаагүй, эсвэл байж болзошгүй буруу илэрхийллийн талаар хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй гэж дүгнэсэн үед”, мөн санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

422502209

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>337,655,599.49</u></b>	<b><u>206,080,398.56</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	12,851,382.83	11,357,908.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,595,000.00	1,460,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	11,256,382.83	9,897,908.55
3351	Байгууллагаас авах авлага	11,256,382.83	9,897,908.55
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	324,804,216.66	194,722,490.01
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	49,723,200.00	45,522,300.00
35110	Тусгай зориулалттай материал	49,331,200.00	45,176,200.00
35130	Эм боох материал	392,000.00	346,100.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	13,764,350.00	14,490,190.00
35410	Бичиг хэргийн материал	144,500.00	162,000.00
35420	Аж ахуйн материал	8,590,300.00	8,970,300.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	603,900.00
35450	Барилгын засварын материал	00.00	1,127,500.00
35470	Бусад хангамжийн материал	5,029,550.00	3,626,490.00
35600	Мал амьтад	261,316,666.66	134,710,000.01
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>59,350,561.03</u></b>	<b><u>56,828,145.45</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	59,350,561.03	56,828,145.45
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	57,325,561.03	54,803,145.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	36,115,613.00	36,115,613.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,623,882.16	-10,640,859.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,280,000.00	66,280,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,277,333.74	-42,696,000.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,237,400.00	25,502,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,774,816.98	-21,396,822.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,618,400.00	11,618,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,249,819.09	-9,979,485.81
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,025,000.00	2,025,000.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,025,000.00	2,025,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>397,006,160.52</u></b>	<b><u>262,908,544.01</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>8,495,287.86</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	8,495,287.86	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	8,495,287.86	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,695,753.86	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	799,534.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	799,534.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>388,510,872.66</u></b>	<b><u>262,908,544.01</u></b>

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	388,510,872.66	262,908,544.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	136,284,000.00	136,284,000.00
51101	Өмч: - төрийн	136,284,000.00	136,284,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	252,226,872.66	126,624,544.01
51210	Өмнөх үеийн үр дүн	287,734,816.75	252,037,809.34
51220	Тайлант үеийн үр дүн	-35,507,944.09	-125,413,265.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>397,006,160.52</u></b>	<b><u>262,908,544.01</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>175,145,318.00</b>	<b>252,899,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,099,618.00</b>	<b>11,099,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25,099,618.00	11,099,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,099,618.00	11,099,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,224,618.00	4,155,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,875,000.00	6,944,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>150,045,700.00</b>	<b>241,800,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	150,045,700.00	241,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,045,700.00	241,800,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>210,653,262.09</b>	<b>378,313,165.33</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>210,653,262.09</b>	<b>378,313,165.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	208,103,262.09	316,195,143.88
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	97,431,760.00	116,278,436.00
210101	Үндсэн цалин	55,147,391.00	79,858,031.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	762,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,522,369.00	36,420,405.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,208,957.66	14,181,340.90
210201	Тэтгэврийн даатгал	8,281,700.97	10,189,891.90
210202	Тэтгэмжийн даатгал	974,316.29	1,236,366.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,582,684.10	800,326.00
210204	Ажилгүйдлийн даатгал	120,567.94	369,390.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,249,688.36	1,585,367.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,632,510.24	5,814,024.75
210301	Гэрэл, цахилгаан	204,426.24	172,554.75
210302	Түлш, халаалт	4,704,590.00	4,879,380.00
210303	Цэвэр, бохир ус	723,494.00	762,090.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,741,016.67	140,147,066.65
210401	Бичиг хэрэг	393,700.00	384,700.00

210402	Тээвэр, шатахуун	10,232,300.00	11,786,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	517,550.00	514,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	130,800.00	174,800.00
210408	Бараа материал акталсны зардал	29,406,666.67	127,286,666.65
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,223,500.00</b>	<b>1,786,900.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,223,500.00	1,786,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>3,109,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	836,800.00
210604	Урсгал засвар	00.00	2,272,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,420,000.00</b>	<b>580,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,420,000.00	580,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,103,300.00</b>	<b>1,322,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,478,000.00	614,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,800.00	109,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	72,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	54,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	438,000.00	473,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>46,342,217.52</b>	<b>32,974,875.58</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,664,681.67	24,187,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,677,535.85	8,787,315.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,550,000.00</b>	<b>62,118,021.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,550,000.00</b>	<b>32,320,067.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	31,090,067.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	1,230,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>29,797,954.45</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		29,797,954.45
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-35,507,944.09</u></b>	<b><u>-125,413,265.33</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-35,507,944.09</u></b>	<b><u>-125,413,265.33</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>158,270,318.00</u></b>	<b><u>246,065,000.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,224,618.00</b>	<b>4,265,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,224,618.00	4,265,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	8,224,618.00	4,265,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,224,618.00	4,265,000.00

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>150,045,700.00</b>	<b>241,800,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	150,045,700.00	241,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,045,700.00	241,800,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>158,270,318.00</b>	<b>246,065,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>158,270,318.00</b>	<b>246,065,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>155,270,318.00</b>	<b>182,926,978.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	98,558,148.67	115,794,629.00
210101	Үндсэн цалин	45,887,144.41	55,739,296.00
210102	Нэмэгдэл	7,360,968.00	19,549,530.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,430,847.26	3,538,859.60
210104	Урамшуулал	00.00	862,960.00
210105	Гэрээт ажлын хөлс	42,879,189.00	36,103,983.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,875,509.09	14,395,445.94
210201	Тэтгэврийн даатгал	8,257,308.38	10,438,453.67
210202	Тэтгэмжийн даатгал	976,225.30	1,219,194.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,257,445.69	804,638.01
210204	Ажилгүйдлийн даатгал	214,213.87	359,238.55
210205	Эрүүл мэндийн даатгал	1,170,315.85	1,573,921.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,632,510.24	5,814,024.75
210301	Гэрэл, цахилгаан	204,426.24	172,554.75
210302	Түлш, халаалт	4,704,590.00	4,879,380.00
210303	Цэвэр, бохир ус	723,494.00	762,090.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,529,450.00	17,859,678.86
210401	Бичиг хэрэг	500,000.00	402,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,232,300.00	16,741,378.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	517,550.00	514,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	219,600.00	201,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,878,400.00	1,741,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,878,400.00	1,741,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,293,500.00	4,617,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	853,000.00	836,800.00
210604	Урсгал засвар	3,440,500.00	3,780,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,502,800.00	1,460,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	614,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,800.00	109,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	53,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	73,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	304,000.00	607,000.00

210807	Газрын төлбөр	00.00	3,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,000,000.00	20,245,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,000,000.00	20,245,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,000,000.00</b>	<b>63,138,021.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,000,000.00	33,340,067.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	31,090,067.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,250,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	29,797,954.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		29,797,954.45
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	136,284,000.00	00.00	286,338,873.60	00.00	422,622,873.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-29,697,062.37	00.00	-29,697,062.37
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>136,284,000.00</b>	<b>00.00</b>	<b>256,641,811.23</b>	<b>00.00</b>	392,925,811.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-35,507,944.09	00.00	-35,507,944.09
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>136,284,000.00</b>	<b>00.00</b>	<b>252,226,872.66</b>	<b>00.00</b>	388,510,872.66
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>136,284,000.00</b>	<b>00.00</b>	<b>252,226,872.66</b>	<b>00.00</b>	388,510,872.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-189,063.32	00.00	-189,063.32
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>136,284,000.00</b>	<b>00.00</b>	<b>252,037,809.34</b>	<b>00.00</b>	388,321,809.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-125,413,265.33	00.00	-125,413,265.33
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>136,284,000.00</b>	<b>00.00</b>	<b>126,624,544.01</b>	<b>00.00</b>	262,908,544.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	261,800,000.00	216,267,045.55
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	261,800,000.00	216,267,045.55
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	226,388,400.00	182,926,978.55
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	147,216,700.00	115,794,629.00
210101	Үндсэн цалин	53,640,000.00	55,739,296.00
210102	Нэмэгдэл	31,736,700.00	19,549,530.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,080,000.00	3,538,859.60
210104	Урамшуулал	12,400,000.00	862,960.00
210105	Гэрээт ажлын хөлс	39,360,000.00	36,103,983.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,058,800.00	14,395,445.94
210201	Тэтгэврийн даатгал	17,298,800.00	10,438,453.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,440,000.00	1,219,194.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,140,000.00	804,638.01
210204	Ажилгүйдлийн даатгал	300,000.00	359,238.55
210205	Эрүүл мэндийн даатгал	2,880,000.00	1,573,921.35
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,100,100.00	5,814,024.75
210301	Гэрэл, цахилгаан	400,000.00	172,554.75
210302	Түлш, халаалт	5,300,100.00	4,879,380.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	762,090.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,181,400.00	17,859,678.86
210401	Бичиг хэрэг	500,000.00	402,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,742,300.00	16,741,378.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	514,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	279,100.00	201,300.00
2105	<b>Нормативт зардал</b>	1,842,700.00	1,741,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,842,700.00	1,741,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,617,200.00	4,617,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	836,800.00	836,800.00
210604	Урсгал засвар	3,780,400.00	3,780,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,121,500.00	1,460,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	614,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	326,000.00	109,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	53,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,300.00	73,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	607,000.00	607,000.00
210807	Газрын төлбөр	3,200.00	3,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,250,000.00</b>	<b>20,245,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,250,000.00	20,245,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,411,600.00</b>	<b>33,340,067.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,411,600.00</b>	<b>33,340,067.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,411,600.00	31,090,067.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,250,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>261,800,000.00</b>	<b>216,267,045.55</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>241,800,000.00</b>	<b>212,002,045.55</b>
132001	Орон нутгийн төсвөөс	241,800,000.00	212,002,045.55
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>20,000,000.00</b>	<b>4,265,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	4,265,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>10.00</b>	<b>10.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

### **Завсрын аудитаар:**

Тус байгууллагад завсрын аудит хийгдээгүй байна.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хөрөнгө зарцуулахтай холбоотой 2,440.1 мянган төгрөгийн 5 шийдвэрийг тус тус мэдээлээгүй, нийт 28,812.0 мянган төгрөгийн 3 худалдан авалтыг хөрөнгө, оруулалт, тендер, худалдан авалт цэст мэдээлээгүй / төсөв, гүйцэтгэл цэст мэдээлсэн /, цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөр дээш 47,194.1 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4.4, 6.4.5, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.9, 2.2.1.13, 2.2.2.1, 2.2.2.2, 2.2.2.5, 2.2.3.2, 2.2.3.6, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.1.11, 3.1.14, 3.1.16 дахь заалтуудтай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар нийт 32,147.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад 32,147.4 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

#### **Залруулсан алдаа:**

1. Цалингийн зардлын дансыг 2,139.6 мянган төгрөгөөр бууруулж бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр

зүйлийн 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй

2. Үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардлыг 100.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
3. Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 29,797.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг зардлыг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй
4. Үр дүнгийн тайланд 109.8 мянган төгрөгийн даатгалын төлбөрийн зардлын ангилал зөрүүтэй тайлагнасан / Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал / нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого , MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй

#### **Залруулаагүй алдаа:**

Байхгүй

#### **Төлбөрийн акт**

Байхгүй

#### **Албан шаардлага**

Байхгүй

#### **Зөвлөмж**

Байхгүй

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Аймгийн Засаг даргын 2024 оны Б/58 дугаар захирамжаар байгууллагын удирдлага солигдож, ажил хүлээлцсэн ба эд хөрөнгө, төсөв санхүүтэй холбоотой зөрчлүүд илэрсэн тул ажлын хэсгийн дүгнэлтээр мэргэжлийн байгууллагаар шалгуулахаар шийдвэрлэсэн байна.
2. Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дугаартай удирдамжаар СХДАА-аас 2018-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн ба шалгалтаар нийт 140,010.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, их эрсдэлтэй гэж үнэлсэн байна. **2024 онд илэрсэн зөрчлүүд:**
  - 2024 оны 11 дүгээр сарын 13-ны байдлаар малын үлдэгдэл 285 байх байтал 118 толгой мал тоолуулсан ба 48,430.0 мянган төгрөгийн 167 толгой мал дутсан
  - Нийт 895 арьсны үлдэгдэл байхаас 11,075.0 мянган төгрөгийн 258 ширхэг арьс дутсан
  - Анхан шатны баримтгүй 7,084.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан, байгууллагын удирдлага ажлаа хүлээлгэн өгсөн байтал хувьдаа 474.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсанОдоогоор хуулийн байгууллагад шилжүүлсэн ба шийдвэр гараагүй байна.

3. Сүүлийн 4 жилийн байдлаар орлогын төлөвлөгөөг 14.9-68.3%-иар дутуу биелүүлсэн байна. Тайлант онд тус байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 20,000.0 мянган төгрөг батлагдсанаас 65.3% буюу 13,055.1 мянган төгрөгөөр дутуу биелсэн байна.
4. Цөм сүргийн үржлийн төв нь ОНӨҮГ статустай боловч 100 хувь орон нутгийн төсвөөс санхүүждэг. Санхүү, үйлдвэрлэлийн төлөвлөгөө, эдийн засгийн зорилтот түвшинг батлуулдаггүй байна.
5. Байгууллагын дансанд бүртгэлтэй бараа материал болон үндсэн хөрөнгийн дансдыг цэгцэлж, чанарын шаардлага хангахгүй бараа материал /арьс зэрэг/, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж устгах үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

Өмнөх онуудад хийсэн аудитаар ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой эсэхийг үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг акталж устгах талаар зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цөм сүргийн үржлийн төв	4	32.1	1	29.8	3	2.3	4	32.1				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>32.1</b>	<b>1</b>	<b>29.8</b>	<b>3</b>	<b>2.3</b>	<b>4</b>	<b>32.1</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цөм сүргийн үржлийн төв													
<b>Дүн</b>													

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Цөм сүргийн үржлийн төв	1	49.6			1	49.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>49.6</b>			<b>1</b>	<b>49.6</b>				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Цөм сүргийн үржлийн төв										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>49.6</b>			<b>1</b>	<b>49.6</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААН	1	1				1		
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		